




2023 оны жилийн тайлан

"ЛэндМН ББСБ" ХК

Дэлхийн эн, Үнэнч сэтгэл, Эвийн хүч



Агуулга

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны
үйл ажиллагааны тайлан

Компанийн тухай

- 04 Эрхэм зорилго
- Алсын хараа
- Үнэт зүйлс

Бизнесийн үйл ажиллагаа

- 08 Мэндчилгээ
- 09 Үйл ажиллагааны хураангуй
- 10 Компанийн онцлох үйл явдал
- 14 Зээлийн үйл ажиллагаа
- 16 Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө
- 18 Хүний нөөц

Санхүүгийн тайлагнал

- 22 Аудитын дүгнэлт
- 23 Орлого, үр дүнгийн тайлан
- Санхүү байдлын тайлан
- 24 Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- 25 Зохистой харьцааны тайлан

Эрсдэлийн удирдлага

- 28 Эрсдэлийн удирдлага

Компанийн засаглал

- 32 Компанийн ерөнхий мэдээлэл
- Компанийн засаглал
- “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилт, түүний үнэлгээ
- 34 Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
- 36 ТУЗ-ийн хурал, үйл ажиллагаа
- 38 Дотоод аудит
- 40 Компанийн бүтэц, зохион байгуулалт
- 42 Удирдлагын баг
- Хувьцааны мэдээлэл
- 43 Ногдол ашгийн мэдээлэл

Компанийн тухай

Дэлхийн эн,
Үнэнч сэтгэл,
Эвийн хүч



Эрхэм зорилго

Хиймэл оюун ухаанд суурилсан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ санхүүгийн салбарт шинэ жишиг тогтоогч таны АНД байна.



Алсын хараа

Дэлхийн энтэй бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ Монголын санхүүгийн зах зээлд манлайлна.



Үнэт зүйлс

Инноваци, Хурд, Ухаалгаар ажиллах
Зогсолтгүй суралцах, Хариуцлага,
Хүн төвт



Зээлийг өөрт хэрэгтэй
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
болгоцгооё!

Бизнесийн үйл ажиллагаа

- Мэндчилгээ
- Үйл ажиллагааны хураангуй
- Компанийн онцлох үйл явдал
- Зээлийн үйл ажиллагаа
- Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө
- Хүний нөөц

МЭНДЧИЛГЭЭ

Өнөөдөр бид Монгол Улсын анхдагч финтек компани болох “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны бүтэн жилийн үр дүнг бахархалтайгаар танилцуулж байна. Бидний амжилтад тууштай зүтгэсэн хамт олон, үргэлж хамт байсан үнэнч хэрэглэгчид, дэмжин ажилласан хувьцаа эзэмшигч болон эрхэм түншүүддээ гүнээ талархаж байгаагаа илэрхийлье. Та бүхний зүрх сэтгэл, мэдлэг туршлага бол бидний амжилтын тулгуур юм.

Бид технологиор дамжуулан бүгдэд нээлттэй, гэгээлэг маргаашийг хамтдаа бүтээх зорилгынхоо хүрээнд 2023 онд Монгол улсын 21 аймгийн өнцөг булан бүрд үйлчилгээгээ цахимаар хүргэж, 204.6 мянган харилцагчийн зээл авахад зарцуулах 614 мянган цаг буюу 70 жилтэй тэнцэх хугацааг хэмнэж, 3.3 сая удаагийн зээлийг цахим хэлбэрээр олгосноор 130 тонн цаас буюу 3,056 ширхэг модыг аварч чадсан гэдгийг дуулгахад таатай байна.

Бид технологиор дамжуулан бүгдэд нээлттэй, гэгээлэг маргаашийг хамтдаа бүтээх зорилготой

2024 оны бидний гол зорилго бол хиймэл оюун ухаан, технологийн мэдлэг ур чадвар дээрээ үндэслэн Монгол Улс даяарх бичил бизнесийн өсөлт, тогтвортой байдлыг нэмэгдүүлэхийн төлөө ажиллах юм. Бичил бизнес бол манай эдийн засгийн ноён нуруу, ажлын байрыг бий болгогч, орон нутгийн хөгжлийг дэмжигч билээ. Тиймээс бид технологиор дамжуулан бичил бизнес эрхлэгч нарын хэрэгцээнд тохируулсан санхүүгийн үйлчилгээг зах зээлд танилцуулах болно. Ингэснээр бид улс эх орныхоо эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, бизнес эрхлэлтийг дэмжин, бүгдэд хүртээмжтэй ирээдүйг бий болгоход нэг алхам ойртох юм.

Технологиор дамжуулан нээлттэй, гэгээлэг маргаашийг хамтдаа бүтээцгээе.



Хүндэтгэсэн:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал


Ц.Ууганбаяр

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Ерөнхийлөгч


Кацухико Мадоно

2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ


Хүүгийн орлого
/Тэрбум төгрөг/



Цэвэр ашиг
/Тэрбум төгрөг/




Зээлийн багц
/Тэрбум төгрөг/




Нийт актив, пассив
/Тэрбум төгрөг/



■ Эздийн өмч ■ Өр төлбөр



Татан төвлөрүүлсэн эх үүсвэр
/Тэрбум төгрөг/



Татвар төлөлт
/Тэрбум төгрөг/



■ ААНОАТ ■ НДШ байгууллага



2023 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

● Монгол улсын хөгжилд бодит хувь нэмэр оруулж буй баялаг бүтээгчдээс тухайн жилийн салбарын шилдгүүд болон манлайлагчдыг тодруулж олон нийтэд төдийгүй олон улсын түвшинд таниулан сурталчлах зорилготой “Bloomberg Awards 2023” арга хэмжээний **“Шилдэг Өсөлт”** номинацийн эзнээр “ЛэндМН ББСБ” ХК шалгарснаас гадна, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо -оос зохион байгуулдаг хөрөнгийн зах зээлийн шилдгийг шалгаруулдаг “Grand Bull Awards 2023” арга хэмжээний **“Шилдэг нээлттэй хувьцаат компани”**-ийн нэгээр шалгарлаа.



● “ЛэндМН ББСБ” ХК-ийн **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал** 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Корпорейт Хотел энд Конвейшн Центрийн “Эвэнт” танхимд амжилттай зохион байгуулагдав. Хурлын үеэр зах зээлд шинээр нэвтрүүлж буй **“FLEXI”** зээлийн бүтээгдэхүүнээ танилцуулж, нээлт хийсэн бөгөөд тус хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.36% нь оролцож, 6 асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэлээ. Мөн “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 сарын 06-ны өдрийн 23/09 тогтоолоор нэгж хувьцаанд 1.75 төгрөг буюу Компанийн 2022 оны цэвэр ашгийн 23.4%, **нийт 1,293,778,000 төгрөгийн ногдол ашгийг** олгохоор шийдвэрлэсний дагуу 2023 оны 04 сарын 28-ны өдөр “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-аар дамжуулан нийт 6,873 хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг үнэт цаасны дансанд байршууллаа.



● Санхүүгийн зохицуулах хорооны 160 тоот “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу финтек зээл олгож буй байгууллагууд нь тухайн финтек зээлийн бүтээгдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороогоор хянуулж, бүртгүүлэх үүрэг хүлээгээд байна. “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьд тус журамд заасан шаардлагуудыг бүрэн хангасан тул Санхүүгийн зохицуулах хороо нь 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр LendMN аппликейшныг холбогдох хууль, журмын **шаардлагыг хангасан** гэж дүгнэж, LendMN аппликейшнээр олгож буй финтек зээлийн бүтээгдэхүүнүүдийг албан ёсоор бүртгэлээ.



● ЛэндМН-ийн итгэл даасан **4 дэх удаагийн нээлттэй “Лэнд Бонд”** нь 24 сарын хугацаатай, жилийн 18%-ийн хүүтэй, улирал тутам хүү төлөгдөх, нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 90,000 ширхэг өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлэх албан ёсны хүндэтгэлийн цан цохих ёслолын үйл ажиллагаа Монголын Хөрөнгийн Биржид амжилттай боллоо. “Лэнд Бонд” -ын анхдагч зах зээлийн арилжаа 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр 10 цагт цан цохиж нээгдсэн даруй нийт 89 хөрөнгө оруулагчдаас **9.0 тэрбум** төгрөгийг татан төвлөрүүлж, амжилттай хаагдлаа. Мөн “Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо” болон “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ны зүгээс Биржийн бус зах зээлийн туршлага, зохистой үйл ажиллагааг үнэлэн **блокчэйд суурилсан платформ** буюу 24 цагаар арилжаалагддаг **анхны үнэт цаас гаргагчийн нэгээр “ЛэндМН ББСБ” ХК** сонгогдлоо.



● ЛэндМН нь 2023 оны 10 дугаар сарын байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан **“Компанийн засаглалын кодекс”**-ыг бүрэн буюу **98.6%** ханган ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос “КОМПЛАЕНСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ” хэлэлцүүлгийг зохион байгуулсан ба уг хэлэлцүүлэгт “ЛэндМН-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Итгэл панелистаар оролцож “Компанийн засаглалын кодекс”-ыг амжилттай хэрэгжүүлж буй туршлага, сайн засаглалын хүрээнд хуримтлуулсан мэдлэгээсээ хуваалцлаа.



● Монголын Финтекийн Холбооноос 2023 оны 9 дүгээр сарын 18, 19 -ний өдрүүдэд **“Frontier Fintech Summit 2023”** арга хэмжээг зохион байгуулсан ба ЛэндМН нь Монголын хамгийн анхны Финтек компанийн хувьд өөрсдийн туршлага, цаашдын алсын хараа зорилгоо хуваалцахын сацуу Дэд захирал Д.Баасандорж **“Финтекийн ирээдүй ба инновац”** сэдвээр илтгэл танилцуулан **ивээн тэтгэгч** байгууллагаар хамтран ажиллалаа. Энэхүү арга хэмжээ нь Монголын финтек салбарын гол төлөөллүүд, олон улсын туршлагатай экспертүүдийг урьж оролцуулан өнөөгийн финтекийн салбарт тренд болж буй чухал сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлж, туршлага хуваалцсан үр дүнтэй арга хэмжээ боллоо.



● ЛэндМН нь MENTOR HUB -тай хамтран хүүхдийн баярыг угтан ирээдүйн эзэд болсон 13-18 насны өсвөр насны хүүхдүүдэд мэргэжлээ зөв сонгох, санхүүгээ хэрхэн зөв удирдахад зориулсан **“САЙН УУ, ИРЭЭДҮЙ МИНЬ”** эвентийн **“ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧ”**-ээр ажиллалаа. Эвентийг зорин ирсэн хүүхдүүдэд Лэндийн ах, эгч нараас нь гарын бэлэг өгснөөс гадна, Lend Plus-Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг танилцуулан мэдээлэл хүргэж санхүүгийн мэдлэгт нь хувь нэмрээ оруулахыг зорин ажиллалаа. Мөн “Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо”-той хамтран **“Бид санхүүч гэр бүл”** сэдэвт хүүхдийн гар зургийн уралдааныг амжилттай зохион байгуулж, ирүүлсэн нийт 116 бүтээлүүдээр “ЛэндМН ББСБ” ХК-ийн Харилцагчийн үйлчилгээний төвд **ҮЗЭСГЭЛЭН** гаргаж, 2023 оны 05-р сарын 30-ны өдөр гар зургийн уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг мэргэжлийн зураач шүүгчдийн багаар дүгнүүлж, уран сэтгэмж, зурах техник, бүтээлч байдлыг харгалзан үзэж 9 хүүхдийн бүтээлийг шилдгээр шалгаруулав. Шилдгээр шалгарсан болон уралдаанд оролцсон бүх хүүхдүүддээ ЛэндМН-ийн ахэгч нараас нь хүүхдийн баярын бэлэг гардуулж, хүүхдийн инээд бялхсан сайхан үйл ажиллагаа болж өнгөрлөө.



● “Ажил олгогчдын зөвлөгөөн 2023”-ыг МҮХАҮТ-д 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс зохион байгуулсан бөгөөд “ЛэндМН ББСБ” ХК-ийг Нийгмийн даатгалын хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, даатгуулагчдын нийгмийн баталгааг хангаж, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгааг үнэлэн 2022 оны **“ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ”**-оор шалгаруулав. Шагналыг Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга Н.Ариунаа “ЛэндМН ББСБ” ХК-ийн Санхүү, үйл ажиллагааны газрын захирал М.Түвшинжаргалд албан ёсоор гардууллаа. ЛэндМН нь үйл ажиллагаагаа явуулж эхлээд 7 жил болж байгаа бөгөөд энэ хугацаанд 2 тэрбум гаруй төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд төлж, нийт ажилтан албан хаагчдын цалин хөлсийг нэг өдөр ч хоцроолгүй олгож, нийгмийн даатгалын тайланг цаг хугацаанд нь тайлагнаж шимтгэл төлөлтийг үнэн зөв цаг хугацаанд тайлагнаж ирсэн билээ.




● ЛэндМН нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ: Ногоон ирээдүй, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтод ажлуудад идэвх чармайлттай жил бүр оролцсоор ирсэн бөгөөд “Минж үржүүлэх, нутагшуулах төв”-д байрлах “Цэцэрлэгт хүрээлэн”-д 2023 оны 05-р сарын 13-ны өдөр Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоонооны Удирдах Зөвлөл, Санхүүгийн зохицуулах хороо, Гишүүн байгууллагуудтай хамтран **4 төрлийн 640 мод** тариалаа. Үүний дараа **“Мод тарих үндэсний өдөр”**-ийг тохиолдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооноос өрнүүлсэн санаачилга, уриалгыг дэмжин 2023 оны 05-р сарын 14-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд байрлах “Инчьеон мөрөөдлийн төгөл”-д мод тариалаа. Энэхүү үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Монголын Ипотекийн корпораци ОССК, Үнэт цаасны төрөлжсөн хадгаламжийн төв, Монголын үнэт цаасны клирингийн төв тэргүүтэй нийт 20 гаруй байгууллагын хамт олон оролцож **1,100 гаруй мод** хамтран тарьж, усалгааг хийж нэрэмжит төглийг бий болголоо. Мөн Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбооноос **“Цус сэлбэлт судлалын үндэсний төв”**-тэй хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг **“Амьдрал бэлэглээ”** цусаа хандивлах аяныг 5 дахь жилдээ 2023 оны 9-р сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулж, тус аянд өнгөрсөн 4 жилийн хугацаанд Холбооны гишүүн 71 ББСБ-ын 910 ажилтан, албан хаагчид оролцож **3,000 хүнд амьдрал бэлэглэжээ**. “Амьдрал бэлэглээ” цусаа хандивлах аянд ЛэндМН-ийн залуус ч жил бүр идэвхтэй оролцож, энэхүү их үйлсэд өөрсдийн хувь нэмрээ орууллаа.



ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2023 онд нийт харилцагч нартаа 996.6 тэрбум төгрөгийн дүнтэй 3.3 сая зээлийг LendMN аппликейшнээр дамжуулан олгосон байна. 2023 онд бүртгэлтэй харилцагчдын тоо 1,218.2 мянгад хүрч өмнөх оноос 7.7%-иар өссөн бол, зээлийн багц 76.4%, олгосон зээлийн дүн 77.4% тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү

ЛэндМН-ийн зээлийн үйл ажиллагааны өсөлт нь харилцагчдын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээгээр ханган ажиллаж байгааг илтгэх ба зээлийн багцын дүнгийн үзүүлэлтээр компани үүсэн байгуулагдсанаас хойш хамгийн дээд хэмжээнд хүрч ажилласан байна.



Зээлийн багцын чанарын үзүүлэлт

2023 онд чанаргүй зээлийн багцад эзлэх хувь 4.1%-д хүрч зээлийн эрсдэлийн сангийн нөөц 5.7 тэрбум төгрөг буюу

зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 109.8%-д хүргэж ажиллалаа.



Компанийн хөрөнгө оруулагчдад
төлсөн нийт хүү

9.5

тэрбум төгрөг

Аж ахуй нэгжийн орлогын албан
татварт төлсөн дүн

5.6

тэрбум төгрөг

Нийгмийн даатгалын шимтгэлд

628.4

сая төгрөг

КОМПАНИЙН НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨ



- ЛэндМН нь санхүүгийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх эрхэм зорилгынхоо хүрээнд тогтмол бус орлоготой харилцагч нартаа зээлийн үйлчилгээг хүргэсээр байна.

- Бид технологийн дэвшлийг ашиглан Улаанбаатар хотод **1** салбартайгаар, харилцагчдадаа цахимаар зээлийн үйлчилгээг үзүүлэхийн сацуу Монгол улсын өнцөг булан бүрд байгаа нотариатуудтай хамтраад зээлийн гэрээ байгуулах боломжийг бүрдүүлэн хүрч үйлчлэн ажиллаж байна.

- Харилцагчийн үйлчилгээний төв нь хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2023 онд нийт **285,063 дуудлага хүлээн авч**, сошиал суваг болон үйлчилгээний заалаар дамжуулан **99,350 хэрэглэгчдэд** үйлчлэн ажилласан байна.

- Нэг хэрэглэгч зээл авахад хамгийн багадаа **3 цаг зарцуулдаг** гэж үзвэл бид цахимаар хамгийн шуурхай зээлийн үйлчилгээг үзүүлснээр **204.6 мянган** харилцагчийн зээл авахад зарцуулах **614 мянган цаг** буюу **70 жилтэй** тэнцэх хэмжээний хугацааг хэмнэх боломжийг олгожээ.

- Нэг удаагийн зээл олголтод дунджаар **15 хуудас цаас** зарцуулдаг. Бид **3.3 сая** удаагийн зээлийг цахим хэлбэрээр баримт бүрдүүлэхгүй олгосноор **130 тонн цаас** хэмнэж **3,056 ширхэг мод** аварчээ.

ХҮНИЙ НӨӨЦ



ЛэндМН
Дүр төрх

→

Хариуцлагатай

Хурдтай

Үр бүтээлтэй

Тасралтгүй суралцагч

Шинийг санаачлагч


Хүнлэг

Эрүүл мэнддээ анхаардаг

Спортлог

←

Манай хамт олон



- **Цалин:** 2023 онд эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран нийт ажилтнуудын цалинг 11% нэмэгдүүллээ.
- **Сэтгэл ханамж:** Компанийн талаарх ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авч ажиллаж байгаа бөгөөд өмнөх оноос 1.67 хувь нэмэгдүүлэн ажиллалаа.
- **Хүний нөөцийн бодлого:** Дотоод үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг гаднын улс орны жишигтэй харьцуулан судалж, гадаад мэргэжилтэнтэй хамтран боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж эхэллээ.
- **Уян хатан нөхцөл:** Ажлын байрны уян хатан цагийн менежментийг бий болгож ажлын цагийг сонголттойгоор ажиллуулах нөхцөлийг бий болголоо.
- **Мэдээллийн урсгал:** Дотоод зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор албан бус хороодыг бий болгон мэдээллийн тасралтгүй байдлыг хангах систем бий болгон ажиллаж эхэллээ.
- **Өглөөний цай:** Сайн үрийн шинэхэн чанасан кофе, бидний хэрэглээний салшгүй хэсэг. Өглөөний цай хөтөлбөрөө үргэлжлүүлэн ажилласан.
- **Чөлөөт цаг:** Бидний ажлын байранд дартс, шатар болон ширээний теннис амралтын танхимд байрлах ба хамт олны хүсэл сонирхлын үүднээс спорт арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллалаа.
- **Эрүүл мэндийн даатгал:** Манай байгууллага ажилтнуудаа даатгалын компанийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд ажилтнуудаа хамруулж урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа.



“Bloomberg Awards 2023”
арга хэмжээний
Шилдэг Өсөлттэй компани
“ЛэндМН ББСБ” ХК



Санхүүгийн тайлагнал

- Аудитын дүгнэлт
- Орлого, үр дүнгийн тайлан
- Санхүү байдлын тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Зохистой харьцааны тайлан



НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компанийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг ЛэндМН ББСБ ХК ("Компани") болон түүний охин компани ("Групп")-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу Группийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлантай тохирч байна.

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан нь Группийн СТОУС-ын дагуу бэлтгэсэн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг орлохгүй.

Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2024 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэд доорх хэсэг багтсан.

- Аудитын онцгойлсон асуудал - Аудитын онцгойлсон асуудал нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудал болох "Харилцагчдад олгосон зээл болон урьдчилганы үнэ цэнийн бууралт" байсан.

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Группийн удирдлагын хариуцлага юм.

Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын Олон Улсын Стандарт ("АУОС") 810 буюу "Санхүүгийн Хураангуй Тайлангийн Талаар Дүгнэлт Өгөх Гэрээт Ажил"-ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.

Ernst & Young Mongolia Audit LLC
Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан

Мандахбаяр Доржбат
Партнер

Баталсан

Адриан Чу
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2024 оны 2 дугаар сарын 5

Орлого, үр дүнгийн тайлан /Нэгтгэсэн/

Орлого, үр дүнгийн тайлан /тэрбум төгрөг/	2021 /аудитлагдсан/	2022 /аудитлагдсан/	2023 /аудитлагдсан/
Хүүгийн орлого	12.49	20.22	47.84
Хүүгийн зардал	(2.80)	(3.95)	(9.53)
Цэвэр орлого	9.69	16.27	38.31
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(0.73)	(1.44)	(2.68)
Үйл ажиллагааны цэвэр орлого	10.42	14.83	35.63
Удирдлагын болон ҮА-ны зардал	(5.95)	(8.29)	(10.26)
Татварын өмнөх ашиг	4.47	6.53	25.37
Татварын зардал	(0.47)	(1.01)	(5.57)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр ашиг	4.00	5.53	19.80
Татварын дараах алдагдал (Зогсоосон үйл ажиллагаа)	(0.11)	-	-
Цэвэр ашиг	3.89	5.53	19.80

Санхүү байдлын тайлан /Нэгтгэсэн/

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2021 /аудитлагдсан/	2022 /аудитлагдсан/	2023 /аудитлагдсан/
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	4.90	5.22	7.89
Зээлийн багц (цэвэр)	32.43	69.59	123.46
Бусад хөрөнгө	0.76	1.05	0.51
Үндсэн хөрөнгө	0.76	0.59	1.25
Биет бус хөрөнгө	0.45	0.40	0.36
Нийт хөрөнгө	39.30	76.85	133.47
Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/			
Өр төлбөр	19.49	52.63	90.74
Эх үүсвэр	15.07	45.96	79.29
Хоёрдогч өглөг	2.95	2.95	2.95
Бусад өглөг	1.47	3.72	8.50
Эздийн өмчийн дүн	19.81	24.22	42.73
Хувьцаат капитал	8.48	8.48	8.48
Хуримтлагдсан ашиг	11.33	15.74	34.25
Нийт өр төлбөр болон эздийн өмч	39.30	76.85	133.47

Мөнгөн гүйлгээний тайлан /Нэгтгэсэн/

Мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/	2021 /аудитлагдсан/	2022 /аудитлагдсан/	2023 /аудитлагдсан/
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(0.88)	(28.48)	(27.84)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0.98	(0.28)	0.07
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(4.70)	29.08	30.44
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт	(4.60)	0.32	2.67
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9.50	4.90	5.22
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4.90	5.22	7.89

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Өмчийн өөрчлөлтийн тайлан /тэрбум төгрөг/	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Бусад нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
2021.01.01-ний өдрийн байдлаар	10.76	(0.99)	0.06	7.88	17.71
Тайлант жилийн цэвэр ашиг				3.89	3.89
Ногдол ашиг				(0.44)	(0.44)
Халаасны хувьцаа		(1.35)			(1.35)
2021.12.31-ний өдрөөр байдлаар	10.76	(2.34)	0.06	11.33	19.81
Тайлант жилийн цэвэр ашиг				5.52	5.52
Ногдол ашиг				(1.11)	(1.11)
2022.12.31-ний өдрийн байдлаар	10.76	(2.34)	0.06	15.74	24.22
Тайлант жилийн цэвэр ашиг				19.80	19.80
Ногдол ашиг				(1.29)	(1.29)
2023.12.31-ний өдрийн байдлаар	10.76	(2.34)	0.06	34.25	42.73

Зохистой харьцааны тайлан

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2023 оны жилийн эцэст 3.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-н стандартын дагуу 5.7 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан.

Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 109.8% -тай тэнцэх хэмжээнд байгуулжээ. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлаар компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд 2023 онд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2021	2022	2023
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	48.6%	28.1%	27.7%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	55.5%	31.5%	29.6%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	50.3%	31.5%	31.6%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	29.4%	12.0%	11.2%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-11.1%	-39.8%	-39.5%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	33.5%	78.5%	79.7%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	32.3%	38.0%	26.5%

Эрсдэлийн удирдлага

Бид хариуцлагатайгаар
санхүүгийн салбарыг манлайлан
ажиллахыг эрхэм болгодог.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“ЛэндМН ББСБ” ХК нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагчид болон хамтран ажиллагч нарынхаа итгэлийг хүлээж бизнесийн ёс зүйг эрхэмлэн ажиллаж, сайн засаглалын хүрээнд Эрсдэлийн Удирдлагын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж ажилладаг.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Эрсдэлийн удирдлагын бодлогоор “Гурван шугамын загвар”- ыг дараах байдлаар тодорхойлон компанийн бүх нэгжүүдийн чиг үүрэг, төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээг уялдуулан ажиллаж байна.

I шугам	II шугам	III шугам
Компанийн бодлого, журам болон өөрсдийн чиг үүргийн хүрээнд өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааныхаа эрсдэлийг хариуцан ажилладаг бизнес нэгжүүд болон тэдгээрийг дэмжих чиг үүрэгтэй нэгжүүд	“Нэгдүгээр шугам”-д хамаарах нэгжүүдийн эрсдэлээ хэрхэн удирдаж байгаад хяналт тавих, компанийн хэмжээнд ямар хэмжээний эрсдэл хүлээж байгааг хянах, хязгаарлах чиг үүрэгтэй нэгжүүд	Хараат бус дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж

Эрсдэл хянан нийцүүлэлтийн нэгж нь Финтек зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл, харилцагчаас хамаарч үүсэх эрсдэлийг тус тус үнэлж түүнийг бууруулах зөвлөмж хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан үе шаттайгаар тогтмол хэрэгжүүлэн ажилласан ба 2023 оны онцлох үйл явдал болох Финтек зээлийн үйлчилгээний эрх зүйн орчин бүрдсэнтэй холбоотойгоор Санхүүгийн Зохицуулах хорооны “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын шаардлагыг бүрэн хангаж Финтек зээлийн бүтээгдэхүүнээр бүртгэгдсэн.

Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэг нь зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас ББСБ алдагдал хүлээх магадлалыг хэлнэ. “ЛэндМН ББСБ” ХК нь зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ эрсдлийн тодорхой орчин нөхцөлд тохируулан эрсдэлийн нөлөөллийг удирдах замаар компанийн ашигт ажиллагаа, өгөөжийг хамгийн өндөр түвшинд байлгахад чиглэдэг.

Комплаенсийн эрсдэл

Комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”, Санхүүгийн зохицуулах хорооны 160 тоот тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагааны журам” батлагдсантай холбоотой “Зээлийн үйл ажиллагааны журам”-г болон “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”, “Хөдөлмөрийн дотоод журам”, “Нууцлалын журам”, “Мэдээлэл технологийн дэд бүтцийн журам”, “Харилцагчийг таньж мэдэх, төлбөр тооцооны эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлд хяналт тавих үйл ажиллагааны журам”, “Биет бус мэдээллийг нөөцлөх, нөхөн сэргээх журам” болон бусад журмыг тухай бүр шинэчлэн үйл ажиллагаандаа нийцүүлэн баталж ажиллалаа.

ЛэндМН-ийн голлох эрсдэлүүд

Гол эрсдэлүүд	Эрсдэлийн үйл явдал, үр дагавар, нөлөөлөл	Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт
Зах зээлийн эрсдэл	- Гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс санхүүгийн алдагдал хүлээх; - Эх үүсвэр болон активын хүүгийн зөрүүгээс санхүүгийн алдагдал хүлээх;	- Гадаад валютын нээлттэй позицийг зохистой түвшинд барин ажиллав. - Эх үүсвэр, активын удирдлагыг оновчтой хэрэгжүүлсэн. - Гадаад валютын ханшийн хэлбэлзлийг тооцон ажиллав.
Санхүүгийн эрсдэл	- Зохистой харьцааны үзүүлэлт алдагдах; - Төлбөрийн чадвар алдагдах буюу хөрөнгө оруулагчийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар буцаан төлөх боломжгүй болох; - Зээлийн эрэлт, өсөлтийг хангахгүй болох; - Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа үзүүлэлт алдагдах;	- Төлөвлөлт сайн хэрэгжүүлсэн. - Тогтмол тайлагнал хийж байв. - Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн. - Эх үүсвэрийн төвлөрлийг удирдсан. - Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулсан бодлого чиглэл баримталж ажиллалаа.
Зээлийн эрсдэл	- Зээлийн багцын чанар буурах; - Зээл төлөгдөхгүй байх магадлал (PD) болон зээлийн алдагдал үүсэх (LGD) магадлал нэмэгдэх;	- Компанийн дотоод бодлого, журам, бүтээгдэхүүний нөхцөлийг шинэчлэн баталлаа. - Зээлийн скоринг, зээлдэгчийн үнэлгээний загвар, аргачлалыг дахин шинэчлэв.
Үйл ажиллагааны эрсдэл	- Биет эд хөрөнгийн зардал; - Бизнесийн үйл ажиллагааны тасалдал; - Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал); - Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй нэр хүндийн гэх мэт);	- Дотоод бодлого, журам, зааврыг шинэчлэв. - Дотоод хяналтын хэрэгжилтийг ханган ажиллалаа. - Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гадаад, дотоод эрсдэлийг үнэллээ.
Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл	- Мэдээлэл алдагдах, түүнийг буруугаар ашиглах; - Мэдээллийн бааз гэмтэх, устах, мэдээлэлд хандах боломжгүй болох; - Системийн эмзэг байдлыг ашиглах;	- ISO 27001:2013 мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэн ажиллалаа. - Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлж, түүнтэй холбоотой журмуудыг шинэчлэн баталлаа. - Системийн эмзэг байдал, цахим халдлага зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлж тогтмол аюулгүй байдлын тест явуулж ажиллалаа.
Байгаль орчин, нийгмийн хариуцлага	- Финтек чиглэлээр санхүүгийн үйлчилгээ зөвхөн иргэдэд үзүүлдэг. Тус үйл ажиллагааг явуулахад байгаль орчинд нөлөөлөх эрсдэл бусад салбартай харьцуулбал харьцангуй бага тул байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг гэж хэлж болно.	- Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахдаа хууль, хянан нийцүүлэлт болон байгаль орчин нийгэмд эрсдэлтэй эсэхийг харгалзан үзэж шийдвэр гаргадаг. Байгаль орчинд ээлтэй эко автомашины зээл гаргав.



**Монголын хамгийн анхны финтек
компани ЛэндМН.**

Компанийн засаглал

- Компанийн ерөнхий мэдээлэл
- Компанийн засаглал
- "Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилт, түүний үнэлгээ
- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
- ТУЗ-ийн хурал, үйл ажиллагаа
- Дотоод аудит
- Компанийн бүтэц, зохион байгуулалт
- Удирдлагын баг
- Хувьцааны мэдээлэл
- Ногдол ашгийн мэдээлэл

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр: "ЛэндМН ББСБ"	МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал: I ангилал
Хэлбэр: Нээлттэй хувьцаат компани	Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг: 800,000,000
Регистрийн дугаар: 5039754	Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо: 7,200 гаруй
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага: Монголын хөрөнгийн бирж	Үндсэн үйл ажиллагааны чиглэл: 1. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх 2. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах 3. Зээл олгох үйл ажиллагаа 4. Факторингийн үйлчилгээ 5. Итгэлцлийн үйлчилгээ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЛэндМН ББСБ" ХК нь Монгол Улсын хууль тогтоомж болон Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани болохынхоо хувьд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, түүнчлэн Монголбанкны холбогдох журам, засаглалын дүрэм, кодексыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

"ЛэндМН ББСБ" ХК (цаашид "Компани") нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, улмаар удирдлагын баг, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын хоорондох цогц

харилцааг төгөлдөржүүлэх, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бий болгохыг үргэлж зорьсоор ирсэн юм.

Манай Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, оролцогч талуудтай үр дүнтэй холбоо үүсгэх, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөв, цаг алдалгүй хүргэх зорилгоор үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар улирал бүрийг болон хагас жилийн хугацааг хамруулан мэдээлэх стратегийг баримталж, нийт 3 удаагийн

тайлан гарган олон нийтэд хүргээд байна.

Ийнхүү 2023 оны I улирлын тайланг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр, II улирал буюу хагас жилийн тайланг 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдөр, III улирлын тайланг 2023 оны 10 дугаар сарын 28-ны өдөр тус тус гарган олон нийтэд мэдээлснээр Компанийн бизнес, засаглал, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг тухай бүр авах боломжийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, харилцагчид болон оролцогч

эзэмшигчид, харилцагчид болон оролцогч талуудад олгож, харилцан итгэлцэл, эргэх холбоо бүхий хамтын ажиллагааг бий болгосон юм.

Түүнчлэн, Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллалаа.

"Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилт, түүний үнэлгээ

Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ыг үйл ажиллагаандаа даган мөрдөж, 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 100%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн

ажилласан байна. Түүнчлэн, "Компанийн засаглалын кодекс" нь тасралтгүй хэрэгжиж, үйл ажиллагааны онцлогоос хамаарч үнэлгээ нь тухай бүр шинэчлэгддэг онцлогтой тул Компанийн зүгээс 100%-ийн гүйцэтгэлээ хадгалахын тулд хүчин зүтгэлээ гарган ажиллах болно.



Хувьцаа эзэмшигчдийн тоо

Анд Системс ХХК	600,000,000
Олон нийт	139,301,683
Халаасны хувьцаа	60,698,317

Хувьцаа эзэмшигчдийн хурал

“ЛэндМН ББСБ” ХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл санхүү, хөрөнгийн зах зээлд шинийг санаачлагч, манлайлагч байсаар ирсэн уламжлалаа хадгалан компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “ХЭЭХ”)-ыг тасалдуулахгүй зохион байгуулан ажилласан билээ.

Компанийн зүгээс Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу 2022 оны ХЭЭХ-ыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 12:00 цагт Улаанбаатар хот, Х ан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандийн гудамж-39, Корпорейт Хотел & Конвейншн центр (Corporate Hotel & Convention Centre)-ийн 2 давхарт байрлах Эвент танхимд зохион байгуулсан ба саналын эрх бүхий хувьцааны 84.36 % буюу 623,709,410 ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноор тус хурал хүчин төгөлдөр болсон ба дараах асуудлыг хэлэлцэн баталсан юм:

- Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
- Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг батлах;
- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн бүрэлдэхүүн



О.БОЛДБААТАР
ТУЗ-ийн дарга
Аудитын хорооны гишүүн
“АНД Глобал” Пти.Лтд-ийн ТУЗ-ийн гишүүн



С.ЭНХ-АМГАЛАН
ТУЗ-ийн гишүүн
Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дарга
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн
“Мэргэн инвестмент” Пти.Лтд-ийн ТУЗ-ийн гишүүн



В.БАЯРСАЙХАН
ТУЗ-ийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн
“Томъёо Эд Тек” ХХК-ийн Үүсгэн байгуулагч / Захирал



Д.ГАЛХҮҮ
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн



С.БОРГИЛ
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн
Аудитын хорооны гишүүн
“Сэргэлт Консалтинг групп”-ийн Гүйцэтгэх захирал



Ж.ЖАРГАЛСҮРЭН
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Аудитын хорооны дарга
“Бейкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Удирдлагын партнер/ Гүйцэтгэх захирал



Б.Хос-Эрдэнэ
ТУЗ-ийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн
“АНД Глобал” Пти.Лтд-ийн Гүйцэтгэх захирал
“АНД Системс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Ц.Ууганбаяр
ТУЗ-ийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн
“АНД Глобал” Пти.Лтд-ийн Санхүү эрхэлсэн захирал
“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал



Б.Итгэл
ТУЗ-ийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын хорооны дарга

ТУЗ-ийн хурал, үйл ажиллагаа

ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой түвшинд удирдах, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг хэрэгжүүлэх, стратегийн зорилтдоо хүрэхэд Компанийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх удирдлагад компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

Компанийн ТУЗ нь ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өнгөрсөн нэг жилийн хугацаанд 5 удаа ээлжит, 7 удаа ээлжит бусаар хуралдан нийт 35 тогтоол гаргажээ. ТУЗ-

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Аудитын хороо	Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо (цаашид “ЗНДЦУХ”)	Эрсдэлийн удирдлагын хороо (цаашид “ЭУХ”)
Бүрэлдэхүүн		
Ж.Жаргалсүрэн (Хорооны дарга) О.Болдбаатар С.Боргил	С.Энх-Амгалан (Хорооны дарга) С.Боргил Д.Галхүү	Б.Итгэл (Хорооны дарга) С.Энх-Амгалан В.Баярсайхан Д.Галхүү Ц.Ууганбаяр Б.Хос-Эрдэнэ

Аудитын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Компанийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон Компанийн газар, албадад өгч ажиллалаа. Түүнчлэн, Компанийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитын байгууллагыг томилох, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд дүгнэлт гаргуулахаар хөндлөнгийн аудитын байгууллагуудтай хийсэн гэрээний дүн 247.8 сая төгрөг, үүнээс 2023 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл 179.5 сая төгрөг байна.

ЗНДЦУХ нь тайлант жилийн хугацаанд нийт 3 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг шинээр сонгох асуудлыг хэлэлцэн Компанийн ХЭЭХ-д танилцуулан шийдвэрлүүлэх тухай шийдвэрлэж, мөн Компанийн мөрдөж буй ажлын үр дүнтэй холбоотой урамшууллын системийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, гүйцэтгэх захирлын томилгоо, гүйцэтгэх захирлын урамшуулалтай холбоотой дүгнэлт гарган ажилласан байна.

ЭУХ нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Компанийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

ТУЗ-ийн гишүүдийн ирц, ажилласан хугацаа болон бусад мэдээлэл

ТУЗ-ийн гишүүдийн нэрс	2022 оны ТУЗ-ийн хурлын ирц	ТУЗ-д ажилласан хугацаа, туршлага	Үнэлгээний хувь
О.Болдбаатар	100%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 6 дахь жилдээ ажиллаж байна.	37,097 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0046%
С.Энх-Амгалан	91.7%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 6 дахь жилдээ ажиллаж байна.	Үгүй
В.Баярсайхан	91.7%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 6 дахь жилдээ ажиллаж байна.	Үгүй
Б.Итгэл	91.7%	ХЭЭХ-аас сонгогдож, 2 дэх жилдээ ажиллаж байна.	520 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0001%
Б.Хос-Эрдэнэ	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 2 дэх жилдээ ажиллаж байна.	Үгүй
Ц.Ууганбаяр	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 2 дэх жилдээ ажиллаж байна.	18,016 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0023%
Ж.Жаргалсүрэн	91.7%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 6 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна.	Үгүй
С.Боргил	100%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 6 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна.	7,076 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0009%
Д.Галхүү	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 2 дэх жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна.	Үгүй

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүр эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй асуудлаар “дэмжсэн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”

санал гаргах боломжтой. ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, хичээл зүтгэл гарган ажилласан гэдгийг ТУЗ-ийн хурлын ирцээс харж болох бөгөөд Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай, ач холбогдолтой шийдвэрүүдийг холбогдох баримт бичиг, судалгаа, тайлбар дүгнэлттэй нэг бүрчлэн танилцсаны үндсэн дээр цаг алдалгүй гаргаж, Компанийн 2023 оны амжилтын голлох хүчин зүйлсийн нэг болсон юм.

ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын мэдээлэл

Компанийн ТУЗ-ийн 2023 оны цалингийн хэмжээ, зарцуулах төсвийг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан ХЭЭХ-аас баталсан билээ. ТУЗ нь батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа ба нэмэлтээр шагнал, нөхөн олговор, бусад урамшуулал олгоогүй болно.

Зардлын зүйл	Гишүүдийн тоо	Сарын цалин (төгрөг)	Сар	Нийт төсөв (төгрөг)
Цалин урамшууллын төсөв	10	10,600,000	12	143,100,000
Дарга	1	1,500,000	12	18,000,000
Хорооны дарга	3	1,200,000	12	43,200,000
Гишүүн	5	1,000,000	12	60,000,000
Нарийн бичгийн дарга	1	500,000	12	6,000,000
НДШ-ийн зардал				15,900,000
Хурал болон бусад зардал				10,000,000
НИЙТ ТӨСӨВ				153,100,000


Дотоод аудит

Дотоод аудитын тогтолцоо: “ЛэндМН ББСБ” ХК нь Хамгаалалтын гурван бүс /Three lines of defence/ бүхий эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэн бүх нэгжийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулан ажилладаг.


Дотоод аудитын тогтолцоог харуулбал:



Дотоод аудитор нь хамгаалалтын гуравдугаар бүсэд хамаардаг бөгөөд нэг ба хоёрдугаар хамгаалалтын бүсийн хүрээнд хяналтын шаардлагууд биелж байгаа эсэхийг хараат бус, бодитой үнэлж дүгнэн баталгаажуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороонд тайлагнаж, гүйцэтгэх удирдлагад зөвлөгөө өгч хамтран ажиллах үүрэг хүлээдэг.



КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



“ЛэндМН ББСБ” ХК-ийн удирдлагын баг



Ц.Ууганбаяр

“ЛэндМН ББСБ” ХК
Гүйцэтгэх захирал

“АНД Глобал” Пти.Лтд-д
7 жил ажилласан.



К.Мадоно

“ЛэндМН ББСБ” ХК
Ерөнхийлөгч

Банк, санхүүгийн салбарт
42 жил, “АНД Глобал” Пти.
Лтд-д
5 жил ажилласан.



Д.Баасандорж

“ЛэндМН ББСБ” ХК
Дэд захирал

“АНД Глобал”
Пти.Лтд-д 2 жил
Банк, санхүүгийн салбарт
3 жил ажилласан.



М.Түвшинжаргал

“ЛэндМН ББСБ” ХК
Санхүү, үйл ажиллагааны
газрын захирал

Банк, санхүүгийн салбарт
18 жил ажилласан.



Ж.Сосор

Бизнес хөгжлийн газрын захирал

Банк, санхүүгийн салбарт
16 жил ажилласан.



Г.Мөнхтулга

Хөрөнгө оруулалт
хариуцсан захирал

Банк, санхүүгийн салбарт
13 жил ажилласан.



Г.Болор-Эрдэнэ

Хүний нөөц,
соёлын албаны менежер

Банк, санхүүгийн салбарт
6 жил ажилласан. Хүний нөөцийн
чиглэлээр 10 жил ажилласан

Хувьцааны мэдээлэл



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж


2023 онд :

- Нийт арилжаалагдсан ширхэг - 25.2 сая ширхэг
- Нийт арилжаалагдсан үнийн дүн - 1.056.0 сая төгрөг
- IPO хийснээс хойш нийт 321.1 сая ширхэг, 15.7 тэрбум төгрөгийн хувьцаа арилжаалагдсан.

Тайлант хугацаанд компани эргүүлэн худалдан авсан халаасны хувьцаа байхгүй ба ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх, урамшуулах хөтөлбөр хэрэгжүүлээгүй болно. 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар компанийн халаасны хувьцаа 60,698,317 ширхэг байна.

Ногдол ашгийн мэдээлэл

Нэгж хувьцаанд зарлагдсан
ногдол ашиг (Төг)



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Ногдол ашгийн бодлогын дагуу 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 23/09 тоот тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2022 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1.75 төгрөг буюу нийт 1,293,778,000 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг шилжүүлсэн билээ.

Мөн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 24/03 тоот тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 8 төгрөг буюу нийт 5,914,413,000 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.



ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

ИМЭЙЛ:

board@lend.mn

2023 оны жилийн тайланг бэлтгэсэн:
Маркетингийн албаны менежер Б.Батбилэг
Хянасан: Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр